

Эмийн хэрэглээний заавар

**ЭТАЦИЗИН 50мг хальсан бүрхүүлт шахмал**  
Аетацизин

**Танд зориулсан чухал мэдээлэл агуулсан тул эмийн бэлдмэлийг хэрэглэхийн өмнө зааврыг сайтар уншина уу.**

- Зааврыг хадгал. Танд дахин унших хэрэг гарч болно.
- Хэрэв танд ямар нэг асуулт байвал эмч, эм зүйчээс лавлана уу.
- Энэ эмийг зөвхөн танд зориулан жоронд бичсэн. Бусдад дамжуулж болохгүй. Хэдийгээр ижил шинж тэмдэг илэрсэн ч бусдад аюултай нөлөө үзүүлж болзошгүй.
- Хэрэв таньд аль нэг гаж нөлөө илэрвэл эмч, эм зүйчид мэдэгдэнэ. Үүнд зааварт тусгагдаагүй гаж нөлөө байж болно. 4 хэсгийг үзнэ үү.

**Агуулга**

1. Этацизин гэж юу вэ, юунд хэрэглэх вэ?
2. Этацизин хэрэглэхийг өмнө мэдвэл зохих зүйлс
3. Этацизин хэрхэн хэрэглэх вэ
4. Боломжит гаж нөлөө
5. Этацизин хэрхэн хадгалах вэ
6. Бусад мэдээлэл

**1. Этацизин гэж юу вэ, юунд хэрэглэх вэ?**

Этацизин 50 мг хальсан бүрхүүлт шахмалын гол идэвхитэй нэгдэл нь зүрхний хэм алдалтын эмгэгийн эмчилгээнд хэрэглэдэг хэм алдалтын эсрэг нөлөөлт *Аетацизин* юм. Суправентрикуляр экстрасистол, ховдлын экстрасистол, суправентрикуляр тахикарди, вентрикуляр тахикарди, тосгуурын трепетани ба фибрилляци зэргийн эмчилгээнд хэрэглэнэ.

**2. Этацизин хэрэглэхийг өмнө мэдвэл зохих зүйлс**

**Этацизиныг дараах тохиолдолд хориглоно:**

- Хэрэв та Этацизин болон найрлага дах бусад нэгдэлд харшилтай бол (6-р хэсэгт жагсаасан);
- Хэрэв та зүрхний бүтцийн ноцтой эмгэгтэй бол:
  - Титэм судасны цочмог хам шинж
  - Зүрхний булчингийн цочмог шигдээс, зүрхний булчингийн цочмог шигдээсийн дараах 3 сар

- Зүүн ховдолын гипертрофи
- Зүрхний хөндийн өргөсөл
- Хэрэв та зүрхний үйл ажиллагааны томоохон эмгэгтэй бол:
  - Зүрхний ноцтой дутагдал (НҮНА III, IV ангилал)
  - Зүрхний дамжуулалт алдагдсан (зүрхний эхо шинжилгээний дүнд)
  - Зүрхний хэм алдагдсан:

Синатриал хориг II анги, бусад синусын зангилааны дамжуулалт саатсан тохиолдол  
Ховдол тосгуурын (AV) хориг II, III анги

Ховдолын доторх дамжуулалтын эмгэг (бүрэн хориг)

- Элэгний хатуурал / бөөрний үйл ажиллагааны эмгэг
- Хөхүүл үе
- Хүүхэд, өсвөр насныхан (18-с доош насны хүүхэд).

Этацизиныг хэм алдалтын эсрэг бэлдмэлүүд болох хинидин, прокаинамид, дисопирамид, ахмалин, моноаминоксидаза (MAO) хориглогчидтой хамт хэрэглэхийг хориглоно.

#### **Анхааруулга, сэрэмжлүүлэг**

Эмчилгээг хамгийн бага эрсдэлтэй, өндөр үр дүнд хүргэхийн тулд эмч эмчилгээний явцад зүрхний үйл ажиллагааг шинжилгээ хийх ёстой.

Зүрхний булчингийн шигдээсийн улмаас үүссэн хэм алдалтын эмчилгээнд Этацизиныг 3 сарын дараагаас болгоомжтой эхлүүлнэ.

Этацизиныг синусын зангилааны сулрах хам шинж, AV хориг I анги, бүрэн хориг, цусны эргэлтийн ноцтой эмгэг, хаалттай өнцөгт нүдний даралт ихдэлт, түрүү булчирхайн томролын эхлэл үед (тунг бууруулах шаардлагатай) маш болгоомжтой хэрэглэнэ.

Этацизин хэм алдалтын урьдал нөлөө (хэм алдалт үүсгэх) үзүүлж болно. Иймээс дараах тохиолдолд анхаарна:

- 1) Хориглох заалтыг хатуу мөрдөнө.
- 2) Гипокалиеми үүсэлтээс сэргийлнэ.
- 3) Эмчилгээг эмнэлэгт эхлэхийг зөвлөнө. Эхний тунгийн дараа, эмийн тунгийн давтан хэрэглээний 3, 5 дах өдөр ЗЦБ, зүрхний идэвхжлийн хяналтыг хийх шаардлагатай.

Элэгний эмгэгтэй өвчтөнд Этацизин элэгний эс хордуулах нөлөө үзүүлж болох тул болгоомжтой хэрэглэнэ.

### **Этацизин эмийн харилцан нөлөө**

Хэрэв та жороор олгодог аль нэг эмийн бэлдмэл хэрэглэж буй бол эмийг хэрэглэхийн өмнө эмч, эм зүйчид мэдэгдэнэ.

Этацизины хэм алдалтын эсрэг бэлдмэлүүд болох хинидин, прокаинамид, дисопирамид, ахмалин, моноаминоксидаза (МАО) хориглогчидтой хамт хэрэглэхийг хориглоно.

$\beta$ -адреноблокаторууд хэм алдалтын эсрэг ялангуяа ачаалал, стрессээр өдөөгдсөн хэм алдалтын эсрэг идэвхийг нэмэгдүүлнэ. Энэ хослолын үед Этацизины тунг бууруулснаар гаж нөлөөний илрэлийн давтамжийг багасгана. Энэхүү хослолыг пароксизмал тахикардын урьдчилан сэргийлэх эмчилгээнд хэрэглэнэ.

Этацизиныг Дигоксинтэй хамт хэрэглэснээр бэлдмэлийн хэм алдалтын эсрэг нөлөө ихсэх, зүрхний булчингийн хурц гэмтлийг сайжруулна. Энэхүү хослолд Дигоксины цусан дах концентраци ихэссэний улмаас дотор муухайрах, хоолны дуршил буурах шинж ажиглагдана. Энэ тохиолдолд Дигоксины тунг багасгах шаардлагатай.

### **Этацизин, хоол хүнс, спирт**

Эмчилгээний явцад согтууруулах ундаа хэрэглэхээс зайлсхийх хэрэгтэй.

### **Жирэмсэн, хөхүүл үе**

Эмийг хэрэглэхийн өмнө эмчээс лавлана уу.

Жирэмсний хугацаанд эмийг хэрэглэх шаардлагатай бол эхэд зүрхний эмчилгээ хийлгээгүй үеийн үр дагавар, шинэ төрөх нярайд үүсэх эрсдлийг сайтар тооцох ёстой.

Этацизин хөхний сүүгээр ялгардаг. Иймээс бэлдмэлийг хөхүүл эмэгтэйд хэрэглэхгүй.

### **Жолоо барих, механизмтай ажиллах**

Бэлдмэл нь толгой эргэх, нүд бүрэлзэх шинж үүсгэж болно. Энэ тохиолдолд жолоо барих, механизмтай ажиллахаас зайлсхийх шаардлагатай.

### **Этацизины зарим найрлагын талаарх чухал мэдээлэл**

Хэрэв эмч танд сахар үл тэвчилтэй гэж хэлж байсан бол эмийг хэрэглэхийн өмнө эмчтэй зөвлөлдөх ёстой.

Шахмалын бүрээсний найрлага дах наран жаргахын шар өнгийн будагч бодис харшлын урвал үүсгэж болно.

## **3. Этацизин хэрхэн хэрэглэх вэ**

Ихэвчлэн эмчийн зааврын дагуу хэрэглэнэ. Хэрэв та итгэлгүй байгаа бол эмчтэй хамт шалгаж болно.

Хоололтоос үл хамааран хангалттай хэмжээний усаар даруулж залгина. Эмч эмчилгээний үргэлжлэх хугацааг тогтооно. Тунг зөвхөн эмчийн заалтаар өөрчилнө.

**Насанд хүрэгчид.** Голдуу 50мг тунгаар (нэг шахмал) өдөрт хоёр-гурван удаа ууна. Эмнэл зүйн нөлөө дутагдалтай тохиолдолд өдөрт 50мг тунгаар дөрвөн удаа болгон нэмэгдүүлж болно. Эмчилгээний үргэлжлэх хугацаа хэм алдалтын төрөл, эмчилгээний үр дүн, эмэнд тэсвэржилт үүсэлтээс хамаарна. Этацизин, β-адреноблокаторуудын хослол өвчтөний онцлогоос хамааран тус тусдаа хэм алдалтын эсрэг тогтвортой нөлөө үзүүлдэг.

**Өндөр настан:** өндөр настанд маш болгоомжтой хэрэглэх ба эхлэх тунг бууруулах, тунг нэмэгдүүлэхдээ болгоомжтой хандана.

**Хүүхэд, өсвөр насныхан (18-с доош насныхан).** Этацизин үр дүн, аюулгүй хэрэглээний үзүүлэлт байхгүй тул хэрэглэхийг хориглоно.

**Элэгний эмгэгтэй өвчтөн.** Элэгний эмгэгтэй өвчтөнд этацизин удаан хугацаанд хэрэглэхэд элэг хордуулах нөлөө үзүүлж болно (элэгний хатууралтай өвчтөнд хэрэглэхийг хориглоно).

Хэрэв та Этацизины нөлөөг хэтэрхий сул, эсвэл хэтэрхий хүчтэй гэж үзвэл эмчтэй зөвлөнө үү.

**Хэрэв та Этацизин хэтрүүлэн хэрэглэсэн бол**

Хэрэв та (хэн нэг нь) Этацизин шахмалыг ихээр хэрэглэсэн бол яаралтай түргэн тусламж дуудах ёстой.

**Хэрэв та Этацизин уухаа мартсан бол**

Мартсан тунгаа давхарлан ууж болохгүй.

**Хэрэв та Этацизин хэрэглээг зогсоох бол**

Хэрэв танд эмийн хэрэглээний талаар ямар нэг асуулт байвал эхлээд эмчтэй зөвлөнө.

#### **4. Боломжит гаж нөлөө**

Бүх эмийн адил этацизин гаж нөлөө үүсгэнэ.

Этацизины хэрэглээнд илрэх гаж нөлөө эмийг өндөр тунгаар хэрэглэх үед голдуу үүсдэг.

*Элбэг (10 хүний 1-с их):*

Толгой эргэх, хуримтлалын эмгэг (эмчилгээний эхэнд), тэнцвэржилтийн эмгэг.

*Ховор (1000 өвчтөнд 1-с их):*

AV хориг, ховдолын дотоод дамжуулалтын эмгэг, зүрхний булчингийн дамжуулалт, зүрхний булчингийн тэжээлийн цусны эргэлтийн дутагдал, ЗЦБ өөрчлөлт, толгой өвдөх, тодор муухайрах, өрц орчим өвдөх шинж үүснэ.

Хэрэв танд зааварт тусгагдаагүй болон тусгагдсан ноцтой гаж нөлөө илэрсэн бол эмчид хэлнэ үү.

#### **5. Этацизин хэрхэн хадгалах вэ**

25°C ихгүй хэмд хадгална. Гэрлийн тусгал, чийгнээс хамгаалан өөрийн саванд хадгална.

Эмийг хүүхэд хүрэхгүй газарт хадгална.

Блистер болон цаасан хайрцагт заасан хугацаа дууссан бэлдмэлийг хэрэглэхгүй.

Үүнд дуусах хугацааны сар, өдрийг бичсэн байна.

Үлдсэн хэсгийг ахуйн хог хаягдал, бохир усанд бүү устга. Удаан хугацаанд хэрэглээгүй эмийг хэрхэн устгах талаар эм зүйчээс асуу. Ингэснээр байгаль орчноо хмагаалахад туслах болно.

#### **6. Бусад мэдээлэл**

##### **Этацизины найрлагад**

Этацизины идэвхтэй бодис (Aethacizinum) 50 мг.

Бусад:

Шахмалын дотор: төмсний цардуул, сукроз, метилцеллюлоз, кальцын стеарат.

Шахмалын бүрээст: сукроз, повидон, кальцын карбонат, магнийн карбонат, цахиур, карнаубын лав, будагч бодисд: хинолины шар (E 104), наран жаргахын шар (E 110), титаны давхар исэл (E171).

##### **Дүрслэл, Савлалт**

Дугариг, хоёр тал гүдгэр, шаргал бүрээст шахмал. Бүрээс, бараг цагаан өнгөний хэсэг шахмалд харагдана.

Блистерт 10 шахмал; 1, 2, 3, 5 блистерийг (10, 20, 30, 50 шахмал) хэрэглэх зааврын хамт цаасан хайрцагт савлана.

Бүх савлагаа худалдаанд гараагүй байж болно.

##### **Маркетингийн зөвшөөрөл эзэмшигч ба үйлдвэрлэгч**

Компаний нэр: Joint-Stock Company Olainfarm

Хаяг: 5, Rupnicu Street, Olaine, LV-2114

Улс: Latvia